

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2024 оны 02 сарын 27-ны  
...-ны  
6699 дугаарт бүртгэв.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 02 сарын 09  
... ны өдөр

Дугаар А/М; А/22

Улаанбаатар  
хот

Журам, маягт, загвар батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.19 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1."Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт-Маягт 1"-ийг 2 дугаар хавсралтаар, "Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалт-Маягт 2"-ыг 3 дугаар хавсралтаар, "Сонгогчдын нэрийн жагсаалтад оруулсан өөрчлөлтийг тусгасан тухай тэмдэглэл-Маягт 3"-ыг 4 дүгээр хавсралтаар, "Сонгогч шилжих хүсэлт-Маягт 4"-ийг 5 дугаар хавсралтаар, "Сонгогч шилжин ирсэн тухай хуудас-Маягт 5"-ыг 6 дугаар хавсралтаар, "Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа-Маягт 6"-г 7 дугаар хавсралтаар, "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалт-Маягт 7"-г 8 дугаар хавсралтаар, "Сонгогчийн бүртгэлийн хуудасны загвар"-ыг 9 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газар /Т.Төгөлдөр/, Мэдээллийн технологийн газар /С.Чинбат/, аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын дарга /Г.Цолмон/, Тагнуулын ерөнхий газрын Тамгын газрын дарга /Н.Бат-Очир/ нарт даалгасугай.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА

  
Д.ДЭЛГЭРСАЙХАН

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА


  
П.ОДОНБААТАР

Бүртгэлийн дугаар: ..... 78

УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон хуульчдын газрын үсэг

2024 оны 02 сарын 09 өдөр



**СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ ҮЙЛДЭХ, НЯГТЛАН ШАЛГАХ,  
ДАВХАРДАЛ ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ, ТАНИЛЦУУЛАХ,  
СОНГОГЧ ШИЛЖИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, түүнд өөрчлөлт оруулах, танилцуулах, хүргүүлэх, сонгогч шилжихэд энэ журмыг баримтална.

Хоёр. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах

2.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/-ын орон нутгийн хэлтэс /цаашид "Улсын бүртгэлийн хэлтэс" гэх/ иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг үндэслэн тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний тоог баг, хороо бүрээр гаргаж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан хугацаанаас өмнө сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

2.2. Улсын бүртгэлийн хэлтэс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлсэн сонгуулийн хэсэг байгуулсан тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд заасан сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэл /цаашид "цахим сан" гэх/-д тусгана.

2.3. Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.2-д заасан мэдээллийг 3 хоногийн дотор нэгтгэн сонгуулийн хэсэг байгуулсан тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын эх хувийн хамт төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.4. Энэ журмын 2.2-т заасны дагуу тусгасан мэдээллийг 5.1.1-т заасны дагуу шалгаж дуусмагц төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр сонгуулийн хэсгийн дугаарыг улсын хэмжээнд давхардахгүй байхаар тогтоох бөгөөд уг шийдвэрийг 5.1.2-т заасны дагуу шалгасны дараа ажлын 5 өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

2.5. Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.4-т заасны дагуу тогтоосон сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй, тухайн сонгуулийн хэсэгт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдэх сонгуулийн эрх бүхий иргэний мэдээллийг цахим санд давхардал, зөрчилгүй оруулна.



2.6. Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.5-т заасан мэдээллийг сонгуулийн хэсэг байгуулсан тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн дараах мэдээлэлтэй тулган шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд тухайн зөрчлийг арилгана:

2.6.1. сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэдийг тухайн сонгуулийн хэсэгт бүрэн бүртгэсэн эсэх;

2.6.2. сонгуулийн эрх бүхий иргэний мэдээллийг давхардалгүй, үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэсэн эсэх;

2.6.3. сонгуулийн эрх бүхий иргэний улсын бүртгэл, түүнтэй холбоотой өөрчлөлтийг тусгасан эсэх;

2.6.4. сонгуулийн эрх бүхий иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тусгасан эсэх;

2.6.5. тухайн сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй иргэн нас барсныг бүртгэсэн бол тусгасан эсэх;

2.6.6. Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллыг сэргээн тогтоосныг бүртгэсэн бол тусгасан эсэх.

2.7. Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.6-д заасан мэдээллийг цахим санд үнэн зөв, бүрэн гүйцэд оруулсан тухай илтгэх хуудсыг иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.8. Төрийн захиргааны байгууллага 2.2, 2.4, 2.6-д заасан мэдээллийг нягтлан шалгасны дараа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар /регистрийн дугаар/, байнга оршин суугаа газрын хаяг гэсэн дарааллаар, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо болон сонгуулийн хэсэг тус бүрээр гаргаж, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэнэ.

Гурав. Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах,  
түүнд өөрчлөлт оруулах

3.1. Төрийн захиргааны байгууллага энэ журмын 2.8-д заасны дагуу үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тухайн сонгууль дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулна.

3.2. Энэ журмын 3.1-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудаст байршуулахдаа тухайн сонгогч өөрийн иргэний бүртгэлийн дугаар эсхүл регистрийн дугаарыг ашиглан сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжийг хангасан байна.

3.3. Төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.1-20.6.3 дахь заалтад заасны дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй тухайн сонгогчийг сонгогчдын

Бүртгэлийн дугаар: 78

УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2017 оны сар 20 өдөр

нэрийн жагсаалтаас хасалгүйгээр “Тайлбар” хэсэгт “Түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээг хийнэ.

3.4.Төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.4, 20.6.5, 20.6.6 дахь заалтад заасны дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн тухайн сонгогчийг байнга оршин суугаа газрынх нь хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасаж, тухайн нутаг дэвсгэрийн хамаарч байгаа сонгуулийн хэсэгт санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад нэмж бүртгэнэ.

3.5.Төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.8 дахь заалтад заасны дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээллийг цахим санд нягтлан шалгаж, хэрэв зөрчилтэй бол зөрчлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.6.Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.8-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтын холбогдох мэдээлэлд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9.1, 20.9.2, 20.9.3, 20.9.4 дахь заалтад заасан өөрчлөлтийг цахим санд тусгаж, нягтлан шалгана.

3.7.Улсын бүртгэлийн хэлтэс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг, энэ журмын 3.3, 3.4, 3.6-д заасны дагуу өөрчлөлт оруулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө цахим сангаас 2 хувь хэвлэж, 1 хувийг сонгуулийн хэсгийн хороонд тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгч, 1 хувийг улсын бүртгэлийн хэлтэст авч үлдэнэ.

3.8.Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 3.6-д заасан өөрчлөлтийн талаарх мэдээ, 3.7-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэж, сонгуулийн хэсгийн хороонд хүлээлгэн өгсөн тухай тайланг сонгуулийн санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагад цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.9.Улсын бүртгэлийн хэлтэс, итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 3.7-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсэгт заасан дараах өөрчлөлтийг эх нотлох баримтыг үндэслэн нягтлан шалгасны үндсэн дээр цахим санд тусгаж, энэ тухай итгэмжлэгдсэн ажилтан Улсын бүртгэлийн хэлтэст, Улсын бүртгэлийн хэлтэс төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэнэ:

3.9.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт;

3.9.2.сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хүйс зэрэг иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;

3.9.3.нас барсан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;

3.9.4.хуулийн 20.6 дахь хэсэгт заасан иргэдийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлт;

3.9.5.сонгогчийн шилжилттэй холбоотой өөрчлөлт.



3.10. Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 3.9-д заасан мэдээллийг үндэслэн “Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа-Маягт 6”-г хэвлэж, итгэмжлэгдсэн ажилтанд нэн даруй мэдээлнэ.

3.11. Төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.9-д заасан өөрчлөлт, гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчийн бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийг сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө оруулна.

3.12. Улсын бүртгэлийн хэлтэс өөрчлөлт оруулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг /Маягт 1/-ийн дагуу цахим сангаас 2 хувь хэвлэж, 1 хувийг сонгуулийн хэсгийн хороонд, 1 хувийг итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгнө.

3.13. Итгэмжлэгдсэн ажилтан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.6 дахь хэсэгт заасны дагуу зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн хүсэлт, магадлагаа, тодорхойлолтыг үндэслэн “Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалт”-ыг Маягт-2 дагуу гаргана.

3.14. Сонгуулийн хэсгийн хороонд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтын бүрэн бүтэн, нууцлал аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтад сонгуулийн хэсгийн хорооны дарга хяналт тавьж ажиллана.

3.15. Энэ журмын 3.7, 3.12-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн санал авах өдөр дуусмагц сонгуулийн хэсгийн хорооны дарга тухайн шатны сонгуулийн хороонд, итгэмжлэгдсэн ажилтан улсын бүртгэлийн хэлтэст тус тус хүлээлгэн өгнө.

Дөрөв. Сонгогч шилжих

4.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь хэсэгт заасан дараах этгээд сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих хүсэлтээ “Сонгогч шилжих хүсэлт Маягт-4”-ийн дагуу шилжин очих сонгуулийн хэсгийн хорооны улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргана.

4.1.1. сонгуулийн байгууллагын ажилтан;

4.1.2. мэдээллийн технологийн багийн гишүүн;

4.1.3. мэдээллийн технологийн даамал;

4.1.4. санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч;

4.1.5. итгэмжлэгдсэн ажилтан;


4.1.6. нэр дэвшигч;

4.1.7. нэр дэвшигчийн менежер;

4.1.8. нэр дэвшигчийн шадар туслагч.

4.2. Сонгогчийн шилжилтийг бүртгэхдээ дараах баримтыг үндэслэнэ.

4.2.1. Журмын 4.1.1-4.1.5-д заасан сонгогч бол тухайн байгууллагынх нь албан бичгийг;



4.2.2. Журмын 4.1.6-4.1.8-д заасан сонгогч бол эрх бүхий байгууллагаас олгосон үнэмлэх.

4.3. Сонгогчийн шилжин очсон сонгуулийн хэсгийн хорооны дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтан “Сонгогч шилжих хүсэлт Маягт-4”-ийн дагуу сонгогчийг тухайн сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад нэмж бүртгэн сонгогчдын нэрийн жагсаалтын “Тайлбар” хэсэгт “Шилжин ирсэн” тухай нэмэлт тэмдэглэгээ хийнэ.

4.4. Итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 4.3-т заасан сонгогчид “Сонгогч шилжин ирсэн тухай хуудас-Маягт 5”-ыг бичиж, түүнийг холбогдох хэсгийг олгох бөгөөд сонгогчийн шилжилтийн талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтэст нэн даруй хүргүүлнэ.

4.5. Улсын бүртгэлийн хэлтэс шилжин ирсэн сонгогчийн мэдээллийг үндэслэн “Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа Маягт 6”-г тухай бүр хэвлэж, итгэмжлэгдсэн ажилтанд хүргүүлнэ.

4.6. Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 4.5 дахь хэсэгт заасны дагуу цахим санд үүссэн лавлагааг үндэслэн “Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа Маягт 6”-г тухай бүр хэвлэж, шилжин явсан сонгогчийн байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн хэсгийн хорооны дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтанд нэн даруй хүргүүлнэ.

4.7. Итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 4.6-д заасан лавлагааг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалтын “Тайлбар” хэсэгт тухайн сонгогчийг шилжсэн тухай “Шилжив” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийнэ.

4.8. Энэ журмын 4.1.1-4.1.5 дахь хэсэгт заасан сонгогч шилжих тухайн байгууллагын албан бичиг, 4.1.6-4.1.8 дахь хэсэгт заасан сонгогчийн бүртгэлийг аймаг, дүүргийн сонгуулийн хорооноос шуурхай гаргуулан авч, сонгуулийн хэсгийн хороонд хүргүүлж, сонгогчийн шилжилтийг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэх ажлыг аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга хариуцна.

4.9. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга энэ журмын 4.8-д заасан мэдээллийг нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Тав. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, түүнд өөрчлөлт оруулах ажиллагаанд хяналт тавих

5.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Тагнуулын байгууллагатай хамтран сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, түүнд өөрчлөлт оруулах, хүргүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан дараах ажиллагаанд хяналт тавина:

5.1.1. Энэ журмын 2.2, 2.5-д заасны дагуу цахим санд тусгасан мэдээллийг сонгуулийн хэсэг байгуулсан дутхай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай тулган шалгах;



5.1.2.энэ журмын 2.4-т заасан сонгуулийн хэсгийг улсын хэмжээнд давхардахгүй зөв дугаарласан эсэх;

5.1.3.энэ журмын 2.8, 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.9-д заасан мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд тусгагдсан эсэх;

5.1.4.энэ журмын 3.10, 4.5, 4.6-д заасны дагуу хэвлэсэн “Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа-Маягт 6” тус бүрийн нотлох баримт хууль, журамд нийцсэн эсэх;

5.1.5.сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээллийг сонгуулийн хэсэг тус бүрийн компьютерт хуулах үйл ажиллагаа;

5.1.6.сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх үйл ажиллагаа;

5.1.7.сонгогчийн бүртгэлийн тоног төхөөрөмж, иж бүрдлийг шалгах, хүлээлгэн өгөх, хүлээн авах үйл ажиллагаа;

5.1.8.Гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчийн бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа.

5.2.Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагааг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч хянаж, баталгаажуулна.

5.3.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, түүнд өөрчлөлт оруулах, хүргүүлэх үйл ажиллагаанд зөрчил илэрсэн тохиолдолд тухайн зөрчлийг арилгуулахаар холбогдох Улсын бүртгэлийн хэлтэст мэдэгдэнэ.

### Зургаа. Сонгогчийн мэдээллийг тулган шалгах

6.1.Итгэмжлэгдсэн ажилтан сонгуулийн санал авах өдөр саналаа өгөхөөр ирсэн сонгогчийн мэдээллийг тухайн сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулган шалгаж, сонгогчид сонгогчийн бүртгэлийн хуудас олгох бөгөөд дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

6.1.1.төрийн захиргааны байгууллагаас сонгуулийн хэсгийн хорооны дарга болон итгэмжлэгдсэн ажилтанд олгосон нэвтрэх кодоор сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарт нэвтэрч, тухайн сонгуулийн хэсгийн нээлтийн тайланг 2 хувь хэвлэж, 1 хувийг сонгуулийн хэсгийн хорооны даргад, 1 хувийг өөрт үлдээх;

6.1.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсэгт заасны дагуу санал авах ажиллагаа эхэлмэгц тухайн сонгуулийн хэсэгт зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчийн мэдээллийг сонгуулийн хэсгийн хорооны даргаас авч, саналын хуудас хүлээн авсан гарын үсэг зурсан нийт сонгогчийн тоог сонгуулийн хэсгийн хорооны даргын мэдээлсэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчийн тоотой тулгах;

6.1.3.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарт иргэний бүртгэлийн дугаар эсхүл регистрийн дугаараар бүртгэж, Сонгогчийн бүртгэлийн хуудсыг 2 хувь хэвлэж, 1 хувийг сонгуулийн хэсгийн хорооны даргад, 1 хувийг өөрт үлдээх;



6.1.4.энэ журмын 6.1.3-т заасан ажиллагааг хийсний дараа санал авах байранд ирсэн сонгогчийн бүртгэлийг эхлүүлэх;

6.1.5.сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг сонгогчийн бүртгэлийн төхөөрөмжид уншуулан таниулж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэгт заасны дагуу бэхэн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан шалгаж, сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарын зураг, бусад мэдээлэлтэй тулган, зөрчилгүй бол Сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

6.1.6.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7-д заасан сонгогчийн бүртгэлийн төхөөрөмж ажиллахгүй, эсхүл ажиллах боломжгүй болсон тохиолдолд сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээлэл, эсхүл иргэний үнэмлэхийн лавлагаа дахь мэдээлэл буюу эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар /регистрийн дугаар/, байнга оршин суугаа газрын хаягийн мэдээллийг өөрт байгаа сонгогчдын нэрийн жагсаалттай тулгаж, жагсаалтын “Тайлбар” хэсэгт тэмдэглэл үйлдэх.

6.1.7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.8 дахь хэсэгт заасан гарын хурууны хээгээр сонгогчийг таних боломжгүй бол сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээлэл, эсхүл иргэний үнэмлэхийн лавлагаа дахь мэдээлэл буюу эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар /регистрийн дугаар/, байнга оршин суугаа газрын хаяг, зургийг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбар дахь мэдээлэлтэй тулгаж, жагсаалтын “Тайлбар” хэсэгт тэмдэглэл үйлдэх;

6.1.8.Итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийн ирц бүртгэлийн программаас сонгогчийн бүртгэлийн хуудсыг 2 хувь хэвлэж, 1 хувийг сонгуулийн хэсгийн хороонд өгч, 1 хувийг өөрт үлдээх.

6.2.Итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 6.1-д заасны дагуу сонгогчийн мэдээллийг тулган шалгахад тухайн сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарт бүртгэгдээгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгохгүй.

6.3.Сонгогчийн иргэний үнэмлэх, иргэний үнэмлэхийн лавлагааны хаягийн бичвэр нь сонгогчдын нэрийн жагсаалт дахь хаягийн бичвэрээс бичилт өөр боловч нэг утгыг илэрхийлж байвал хаягийн бүртгэлийн зөрүү гэж үзэхгүй.

6.4.Итгэмжлэгдсэн ажилтан сонгогчдын нэрийн жагсаалтад “Түр хасав” нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн сонгогчийн бичгээр гаргасан хүсэлт, түүний үндэсний энгийн гадаад паспорт, холбогдох бусад нотлох баримтыг үндэслэн сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг уншуулан таниулж, мэдээллийг тулган шалгасны дараа сонгуулийн хэсгийн хорооны дарга болон түүнд олгосон кодоор “Түр хасав” нэмэлт тэмдэглэгээг сэргээж, сонгогчдын нэрийн жагсаалтын “Тайлбар” хэсэгт энэ тухай тэмдэглэнэ.

6.5.Энэ журмын 6.4-т заасан сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад “Түр хасав” нэмэлт тэмдэглэгээг хүчингүй болгосныг баталгаажуулж гарын үсэг зурна.

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2017.08.02 сарын 26 өдөр

6.6.Итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 6.5-д заасан сонгогчид сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

6.7.Төрийн захиргааны байгууллага сонгуулийн хэсгийн хорооны дарга болон итгэмжлэгдсэн ажилтанд сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарт нэвтрэх, сэргээх, нээх, хаах, түгжих кодыг сонгуулийн санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө хүлээлгэн өгсөн байна.

6.8.Итгэмжлэгдсэн ажилтан сонгуулийн санал авах өдөр сонгогчийн бүртгэлийн нээлтийн, явцын, хаалтын тайланг эрх бүхий төрийн байгууллагаас тогтоосон хугацаанд хэвлэж, Улсын бүртгэлийн хэлтэст мэдээлнэ.

Долоо. Бусад

7.1.Улсын бүртгэгч "Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа"-г хэвлэж, лавлагаанд өөрийн дугаар бүхий тэмдэг дарж, гарын үсэг зурах бөгөөд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.

7.2.Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж, байгууллагын архивт холбогдох журмын дагуу хүлээлгэн өгнө.

7.3.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

- оОо -

Бүртгэлийн дугаар: ..... 78 .....

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

.....

20... он... сар... өдөр

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 09 сарын 25 ны өдрийн /111/ дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

Маягт 1

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН  
СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

Сонгуулийн тойргийн дугаар: \_\_\_\_\_  
Сонгуулийн хэсгийн дугаар: \_\_\_\_\_

№	СОНГОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ						Саналын хуудас авсан сонгогчийн гарын үсэг	Тайлбар
	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Нас	Хүйс	Иргэний бүртгэлийн дугаар / Регистрийн дугаар/	Байнга оршин суугаа газрын хаяг		
1	2	3	4	5	6	7	8	9

Жагсаалт гаргасан:

\_\_\_\_\_ АЙМАГ/ ДҮҮРГИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Тэмдэг

\_\_\_\_\_ /  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_ /  
(Гарын үсгийн тайлал)

\_\_\_\_\_ УЛСЫН БҮРТГЭГЧ

\_\_\_\_\_ /  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_ /  
(Гарын үсгийн тайлал)

Тэмдэг

эсхүл

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТАН

\_\_\_\_\_ /

\_\_\_\_\_ /  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_ /  
(Гарын үсгийн тайлал)

\_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр

Бүртгэлийн дугаар: ..... 78


**УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

**ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажлтын гарын үсэг

.....

20\_\_ он \_\_ сар \_\_ өдөр



Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 09 сарын 03 ны өдрийн 114/АБ дугаар хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт

Маягт 2

**ЗӨӨВРИЙН БИТҮҮМЖИЛСЭН САНАЛЫН ХАЙРЦГААР  
САНАЛ ӨГӨХ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ**

Сонгуулийн тойргийн дугаар: \_\_\_\_\_  
Сонгуулийн хэсгийн дугаар: \_\_\_\_\_

№	СОНГОГЧИЙН						Саналын хуудас авсан сонгогчийн гарын үсэг	Тайлбар
	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Нас	Хүйс	Иргэний бүртгэлийн дугаар / Регистрийн дугаар/	Байнга оршин суугаа газрын хаяг		
1	2	3	4	5	6	7	8	9

Жагсаалт гаргасан: \_\_\_\_\_  
АЙМАГ/ ДҮҮРГИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Тэмдэг \_\_\_\_\_ (Гарын үсэг) \_\_\_\_\_ (Гарын үсгийн тайлал)

\_\_\_\_\_ УЛСЫН БҮРТГЭГЧ

Тэмдэг эсхүл \_\_\_\_\_ (Гарын үсэг) \_\_\_\_\_ (Гарын үсгийн тайлал)


УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТАН

\_\_\_\_\_ (Гарын үсэг) \_\_\_\_\_ (Гарын үсгийн тайлал)



\_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр

20\_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр



Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 04 сарын 04 ны өдрийн 411/04 дугаар хамтарсан тушаалын 4 дүгээр хавсралт

Маягт 3

**СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТУСГАСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

... оны ... дугаар сарын ...ны өдөр

Аймаг /нийслэл: \_\_\_\_\_

Сум/дүүрэг: \_\_\_\_\_

Сонгуулийн тойргийн дугаар: \_\_\_\_\_

Сонгуулийн хэсгийн дугаар: \_\_\_\_\_

Д/д	Сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгогчдын тоо	Лавлагааны тоо			Лавлагааг тусгасан байдлаар сонгогчдын тоо
		Нэмэгдсэн	Хасагдсан	Иргэний улсын бүртгэлтэй холбоотой бусад өөрчлөлт	
1	2	3	4	5	6

Хүлээлгэн өгсөн:

\_\_\_\_\_ АЙМАГ/ ДҮҮРГИЙН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Тэмдэг

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТАН

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Хүлээн авсан:


\_\_\_\_\_ ДУГААР СОНГУУЛИЙН ХЭСГИЙН ХОРООНЫ ДАРГА /эсхүл НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Тэмдэг



Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 02 сарын 17-ны өдрийн А/14/2024 дугаар хамтарсан тушаалын 5 дугаар хавсралт



Маягт 4

### СОНГОГЧ ШИЛЖИХ ХҮСЭЛТ

Дугаар \_\_\_\_\_

\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр

\_\_\_\_\_ аймаг/нийслэл \_\_\_\_\_ сум/дүүргийн \_\_\_\_\_ дугаар

р  
баг/хорооны \_\_\_\_\_ байр/гудамжны \_\_\_\_\_ то

от \_\_\_\_\_ хаягт \_\_\_\_\_ оршин \_\_\_\_\_ суугч \_\_\_\_\_ /регистр/бүртгэлийн  
дугаартай \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь \_\_\_\_\_


\_\_\_\_\_ шалтгаанаар \_\_\_\_\_ аймаг/нийслэлээс явах болсон тул Монгол Улсын Их Хурлын ээлжит \_\_\_\_\_ оны сонгуулийн \_\_\_\_\_ дугаар тойргийн \_\_\_\_\_ дугаар сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасаж, \_\_\_\_\_ аймаг/нийслэлийн сонгуулийн \_\_\_\_\_ дугаар тойргийн \_\_\_\_\_ дугаар сонгуулийн хэсэгт шилжүүлж өгнө үү.

Хавсралт: ... хуудастай.



Хүсэлт гаргасан: \_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_ /  
(Гарын үсгийн тайлал)

\*Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24.1-т заасан \*Сонгуулийн байгууллагын ажилтан, \*Итгэмжлэгдсэн ажилтан, \*Мэдээллийн технологийн багийн гишүүн, \*Даамал, \*Санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах аар ажиллаж байгаа цагдаагийн албан хаагч тухайн байгууллагын албан бичиг, 24.2 дахь хэсэгт заасан \*Нэр дэвшигч, \*Менежер, \*Шадар туслагч эрх бүхий байгууллагаас олгосон үнэмлэх, холбогдох материалыг хавсаргана.



2024 он 02 сар 17 өдөр



Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 11 сарын 10 ны өдрийн 11/11, 11/10 дугаар хамтарсан тушаалын 6 дугаар хавсралт

Маягт 5

/Сонгогчид олгох хувь/

**СОНГОГЧ ШИЛЖИН ИРСЭН ТУХАЙ ХУУДАС**

Дугаар\_\_

\_\_\_\_\_  
/Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр/ иргэний бүртгэлийн /регистрийн дугаар/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24.1, 24.2 дахь хэсэгт заасан этгээд /аль нь болохыг бичих/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн \_\_\_\_ дугаар тойргийн \_\_\_\_ дугаар сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэж, Сонгогч шилжин ирсэн тухай хуудас олгов.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн \_\_\_\_ дугаар тойргийн  
\_\_\_\_ дугаар сонгуулийн хэсгийн хорооны дарга /эсхүл нарийн бичгийн дарга/  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг) /\_\_\_\_\_  
(Гарын үсгийн тайлал)

Улсын бүртгэлийн байгууллагын  
итгэмжлэгдсэн ажилтан  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг) /\_\_\_\_\_  
(Гарын үсгийн тайлал)

\_\_ он \_\_ сар \_\_ өдөр

/Итгэмжлэгдсэн ажилтанд үлдэх хувь/

**СОНГОГЧ ШИЛЖИН ИРСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

Дугаар\_\_

Монгол Улсын Их Хурлын \_\_\_\_ оны ээлжит сонгуулийн \_\_\_\_ дугаар тойргийн \_\_\_\_ дугаар хэсгийн хорооноос шилжих тухай хүсэлтийг үндэслэн

\_\_\_\_\_  
/Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр/ иргэний бүртгэлийн /регистрийн дугаар/


Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24.1, 24.2 дахь хэсэгт заасан этгээд /аль нь болохыг бичих/ Монгол Улсын Их Хурлын \_\_\_\_ оны ээлжит сонгуулийн \_\_\_\_ дугаар тойргийн \_\_\_\_ дугаар хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн \_\_\_\_ дугаар тойргийн  
\_\_\_\_ дугаар сонгуулийн хэсгийн хорооны дарга /эсхүл нарийн бичгийн дарга/  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг) /\_\_\_\_\_  
(Гарын үсгийн тайлал)

Улсын бүртгэлийн байгууллагын  
итгэмжлэгдсэн ажилтан  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг) /\_\_\_\_\_  
(Гарын үсгийн тайлал)

\_\_ он \_\_ сар \_\_ өдөр





Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 04 сарын 09 ны өдрийн АНХ/МЭ дугаар хамтарсан тушаалын 7 дугаар хавсралт

Маягт 6

**СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ЛАВЛАГАА**

Лавлагаа үүссэн огноо: \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр

Лавлагаа хэвлэсэн огноо: \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр

Регистрийн дугаар /Иргэний бүртгэлийн дугаар/:

Ургийн овог:

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Нас/хүйс:

Төрсөн он, сар, өдөр:

Байнга оршин суугаа газрын хаяг:

Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан утга:

Монгол Улсын Их Хурлын ... оны ээлжит сонгуульд санал өгөх газар: аймаг/ дүүрэг нэр:

Сонгуулийн тойргийн дугаар:

Сонгуулийн хэсгийн дугаар:

Сонгогчдын нэрийн жагсаалтад оруулсан өөрчлөлт:

\_\_\_\_\_ аймаг /дүүрэг/-ийн  
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

\_\_\_\_\_ улсын бүртгэгч

\_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

\_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Тэмдэг

Тэмдэг

Лавлагааг хянасан:.....аймаг/дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч \_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_

Тэмдэг


(Гарын үсэг)

(Гарын үсгийн тайлал)

Лавлагааг үндэслэн жагсаалтад нэмэлт, хасалт, өөрчлөлт оруулсан утга:

Монгол Улсын Их Хурлын \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сонгуулийн \_\_\_\_\_ дугаар сонгуулийн тойргийн \_\_\_\_\_ дугаар сонгуулийн хэсэгт ажилласан улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан

\_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_  
(Гарын үсэг)



Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 04 сарын 06 ны өдрийн АН/10 дугаар хамтарсан тушаалын 8 дугаар хавсралт



Маягт 7

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН  
ГАДААД УЛСАД БАЙГАА СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

Улсын нэр: \_\_\_\_\_

№	СОНГОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ						Саналын хуудас авсан сонгогчийн гарын үсэг	Тайлбар
	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Нас	Хүйс	Иргэний бүртгэлийн дугаар /Регистрийн дугаар/	Байнга оршин суугаа газрын хаяг		
1	2	3	4	5	6	7	8	9

Жагсаалт гаргасан:

\_\_\_\_\_ САЛБАР КОМИССЫН  
ДАРГА


Тэмдэг

\_\_\_\_\_ /  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_ /  
(Гарын үсгийн тайлал)

\_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр





Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын 2024 оны 09 сарын 08 ны өдрийн 1111/2024 дугаар хамтарсан тушаалын 9 дүгээр хавсралт

Загвар

СОНГОГЧИЙН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

**СОНГОГЧИЙН БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

Эцэг /эх/-ийн нэр: \_\_\_\_\_  
 Өөрийн нэр: \_\_\_\_\_  
 РД: \_\_\_\_\_

Иргэний бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_

Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн дугаар: \_\_\_\_\_

Зөөврийн хайрцгаар\*  
 Төлөв сэргээсэн\*  
 Гадаад улсад санал өгсөн\*

Монгол Улсын Их хурлын \_\_\_\_\_ оны ээлжит сонгууль

Сонгуулийн тойргийн дугаар: \_\_\_\_\_  
 Сонгуулийн хэсгийн дугаар: \_\_\_\_\_

Улаанбаатарын цагаар

Бүртгэсэн огноо, цаг: \_\_\_\_\_  
 Хэвлэсэн огноо, цаг: \_\_\_\_\_

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчийн бүртгэлийн хуудас "Зөөврийн хайрцгаар"

"Түр хасаа" төлөв сэргээсэн сонгогчийн бүртгэлийн хуудас "Төлөв сэргээсэн" гэсэн тэмдэглэгээтэй хэвлэгдэнэ.

